



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 139

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дах заалт, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.3 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 25,000,000 /хорин таван сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй ДУА 11-59 улсын дугаартай УАЗ пургон маркийн автомашиныг акталж, устган, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг актлах, автомашины акталснаас гарсан сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 1 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын
23-ны өдрийн 199 тогтоолын хавсралт



Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	УАЗ 220893 033	ДУ А	11-59	2013	2013.09.09	374100D00 418904	410400 D00047 93	2890.D	157096	25 000 000	25 000 000	0
Хөрөнгийн дүн												25,000,000 /хорин таван сая төгрөг/	